



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 4/124

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 259 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 31 өдрийн А/323 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19) -ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагааг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмыг мөрдөж, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал цахимаар, 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмыг мөрдөж удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (О.Уранзаяа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

